



# АРЛИНГТОН УЛСЫН СУРГУУЛИУДЫН БАГА СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ, ЖУРАМ

2022-2023 он



Бага сургуулийн сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, журмыг Арлингтон улсын сургуулиудын вэбсайтаас цахим хэлбэрээр авах боломжтой.



2022 оны 8-р сар

Арлингтоны улсын сургуулиудын Бага сургуулийн сургалтын хөтөлбөрт тавтай морил! Бид таныг Арлингтоны улсын сургуулиудад оролцож буйд талархаж, таны хүүхдийг боловсронгуй сургалтын хөтөлбөрт хамруулахыг зорьж байна.

Энэ баримт бичиг буюу *Бага сургуулийн сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, журамд* Арлингтоны бага сургуулийн хүүхдүүдэд хамаарах журам, хөтөлбөр, авах боломжтой үйлчилгээний талаарх мэдээллийг өгдөг. Ойлгомжтой, товч тодорхой болгохын тулд манай бага сургуулиудын тухай олон товч, бодитой тайлбарыг өгсөн. Эдгээр ихэнх сэдвийн талаар нэмэлт мэдээлэл авч болох бөгөөд Арлингтон улсын сургуулиудын вэбсайтаас авч болно. Асуулт асуух эсвэл нэмэлт мэдээлэл авах хүсэлтэд зориулж утасны дугаарыг өгсөн.

*Бага сургуулийн сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, журамд* Арлингтон улсын сургуулиудын дараахыг хийх үүрэг амлалтыг тусгасан:

- сурагч бүрийг сорьж, сурагчдыг амжилт гаргах олон арга замаар хөгжүүлэх
- эрүүл, аюулгүй, дэмжлэгтэй сургалтын орчинд бүх сурагчдын оюуны, бие бялдар, сэтгэц, нийгэмшил, сэтгэл санааны хөгжлийг төлөвшүүлэх
- сурагчдыг боловсролын болон амьдралын дараагийн алхмын турш амжилт гаргахад нь бэлтгэх
- сурагчийн хэрэгцээг хангах нэмэлт үйлчилгээгээр дамжуулан сурлагад дэмжлэг үзүүлэх

Чиг баримжаа олгох, хичээл эхлэх өдөрлөг, эцэг эхийн хурал, бусад товлот үйл ажиллагааны үеэр бид таныг хүүхдийнхээ сургуулийн захирал, багш нартай харилцаж, уулзахыг зөвлөж байна. Та мөн утсаар ярьж, ганцаарчлан уулзах цаг товлох боломжтой.

Арлингтоны улсын сургуулиудтай нэгдэж, манай дүрэм журам, хөтөлбөр, үйлчилгээтэй танилцсанд баярлалаа. Хүүхдийнхээ боловсролд үргэлжлүүлэн идэвхтэй оролцоорой. Манай хамт олон таны хүүхдийн сурч боловсроход дэмжлэг үзүүлэхийн тулд тантай хамтран ажиллахад бэлэн байна.

Арлингтон улсын сургуулиуд  
Сургалтын алба

Гарчиг

<b>ЖУРМЫН МЭДЭГДЭЛ</b>	<b>7</b>
<b>ЖУРМЫН МЭДЭЭЛЭЛ: ЭЛСЭЛТ</b>	<b>8</b>
<b>ЖУРМЫН МЭДЭЭЛЭЛ: ГЭРИЙН ДААЛГАВАР, ЗУНЫ ДААЛГАВАР</b>	<b>9</b>
<b>ЖУРМЫН МЭДЭЭЛЭЛ: СТАНДАРТЧИЛСАН ШАЛГАЛТ</b>	<b>10</b>
<i>Намар, хагас жилийн бага сургуулийн өсөлтийн үнэлгээ</i>	<b>10</b>
<i>5,6-р сарын бага ангийн СС шалгалт</i>	<b>10</b>
<b>ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАГА СУРГУУЛИЙН ӨДӨРЛӨГ</b>	<b>11</b>
<b>СТАНДАРТАД СУУРИЛСАН ТАЙЛАН</b>	<b>11</b>
<b>УЛАМЖЛАЛТ ТАЙЛАН БА-5-р АНГИ</b>	<b>11</b>
<i>Бүх агуулгын чиглэлийн уламжлалт тайлан 1-2-р анги</i>	<b>11</b>
<i>Уран зохиол (Бичих, Унших), математик, шинжлэх ухаан, нийгэм судлалын уламжлалт тайлан 3-5-р анги</i>	<b>11</b>
<b>ЖУРМЫН МЭДЭЭЛЭЛ – АНГИ ДЭВШИХ, ҮЛДЭЭХ</b>	<b>11</b>
<b>ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>11</b>
<b>ХОЛБООНЫ БОЛОН МУЖИЙН ХӨТӨЛБӨР</b>	<b>11</b>
<b>БУСАД ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>11</b>
<b>СУРГАЛТЫН ЧИГЛЭЛҮҮД</b>	<b>11</b>



## ЖУРМЫН МЭДЭГДЭЛ

АУС сургуулийн зөвлөлийн дүрэм журмын талаар нэмэлт мэдээлэл авахын тулд дараах холбоосыг ашиглана уу:

<https://www.apsva.us/school-board-policies/>

### Элсэлт

Арлингтон дүүргийн оршин суугчдын хүүхдүүд 9-р сарын 30-ны өдөр эсвэл түүнээс өмнө таван нас хүрсэн бол Арлингтоны сургуульд үнэ төлбөргүй суралцах эрхтэй. Эцэг эх хүүхдээ бэлтгэл ангид оруулахыг хүсэхгүй бол харьяа сургуульд мэдэгдэх ёстой. Зургаан нас хүрэхэд нь хүүхдийг сургуульд бүртгүүлж оруулах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг Төвийн 703-228-8000 дугаар эсвэл <https://www.apsva.us/registering-your-child/> вэбсайтаас авч болно.

Арлингтон хотын бэлтгэл анги эсвэл бага сургуулийн өөр ангид анх удаа элсэж буй сурагчид дараахыг хийх ёстой:

1. Төрсний гэрчилгээ эсвэл төрсөн огнооны бусад хүчинтэй нотлох баримт.
2. Сургуульд явах өдрөөс 12 сарын өмнө эрүүл мэндийн үзлэг хийлгэх.
3. Сахуу, хөхүүл ханиалга, татран, халдварт саа, гепатит В (6-р ангид), улаанбурхан, гахайн хавдар, улаанууд (Герман улаанбурхан) өвчний эсрэг дархлаажуулалт хийсэн өдөр/сар/онг харуулсан эрүүл мэндийн мэдээлэл (тусгай зөвшөөрөлтэй эмчийн гэрчилгээ).
  - Ү Аль ч сургуульд анх элсэн ороход улаанбурхан, гахайн хавдар, улаанууд (Герман улаанбурхан) өвчний эсрэг хоёр дахь дархлаажуулалтын он/сар/өдрийг заасан нотлох баримт (тусгай зөвшөөрөлтэй эмчийн тодорхойлолт).
  - Ү Арлингтоны улсын сургуульд элссэнээс хойш нэг жилийн дотор эсвэл элсэлт завсарласны дараах туберкулины арьсны сорилын бичгээр өгсөн хариу.
  - Ү Шашны үндэслэлээр дархлаажуулалт хийлгэхээс татгалзсан өрх сургуулиас авч болох Виржиниа мужийн тусгай маягтыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх ёстой. Түүнчлэн шаардлагатай нэг эсвэл нэгжгээд дархлаажуулалт сурагчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд эмч эрүүл мэндээр чөлөөлөх хүсэлтэд гарын үсэг зурах ёстой.
4. Оршин суух газрын тодорхойлолт эсвэл Арлингтон дүүрэг руу жар (60) хоногийн дотор нүүх тухай баримтыг бүрдүүлэх ёстой. Оршин суугаа газрын тодорхойлолтод түрээслүүлэгч, түрээслэгч, түрээслэгчийн гарын үсэг зурсан хүчинтэй түрээс гэрээ, эсвэл эцэг эх/асран хамгаалагч нь орон сууц эзэмшиж, Арлингтон дүүрэгт оршин суудаг болохыг харуулсан байрны зээлийн гэрээний хуулбар орно. Дүрмээс гажих тохиолдлыг Арлингтоны сургуулийн журамд жагсаасан. Арлингтон сургуулийн журмыг сургууль бүр, Сайфакс боловсролын төв, нийтийн номын сан, вэбээс авах боломжтой. <https://www.apsva.us/school-board-policies/>

*Хүүхэд аль сургуульд суралцах ёстойг мэдэхийн тулд Арлингтоны улсын сургуулиудын дүүргийн сургууль, олон нийттэй харилцах албаны 703-228-6005 дугаарт залгаж эсвэл <https://www.apsva.us/boundary-locator/> дэх цахим хил хязгаарын мэдээллийг ашиглана уу.*

### Гэрийн даалгавар

Арлингтон улсын сургуулиуд сурагчдад дадлага хийх, бэлтгэх, судлах болон/эсвэл гүнзгийрүүлж суралцах боломжийг олгодог судалгаанд суурилсан тэгш эрхтэй гэрийн даалгаврыг дэмждэг. Гэрийн даалгавар агуулгын стандартад нийцэж, нэмэлт материал эсвэл насанд хүрэгчдээс их дэмжлэг авах шаардлагагүйгээр бүх сурагч хийж чадахуйц байх ёстой. Багш гэрийн даалгаврын үнэлэхдээ тухайн агуулгын хүрээнд сурагч мэдлэг, чадвараа харуулсан эсэхэд анхаарч, сурагч, эцэг эхчүүдэд цаг тухайд нь, тууштай, ойлгомжтой, тогтмол мэдээлэх хэрэгтэй. Гэрийн даалгаврын үнэлгээнд сурагчийн зан байдлын үнэлгээг тусгах ёсгүй.

Гэрийн даалгавар дараах нөхцөлийг хангана:

- Ү Бататгах, дадлагажихыг урьтал болгож, тохиромжтой бол гүнзгийрүүлж суралцах
- Ү Сурагч болон эцэг эх/асран хамгаалагчдад тодорхой мэдэгдэх.
- Ү Сурагчийн нас, хөгжлийн төлөв байдалд тохирсон байх

- Ү Хичээлийн бус цагаар сурагч болон гэр бүлийнх нь үйл ажиллагааны хувьд цаг хугацаа бага шаардаж, хамгийн бага нөлөөлөх
- Ү Дараах арга замаар Виржиниа мужийн Боловсролын газраас тодорхойлсноор сурагчийг төгсөхөд нь амжилт гаргахад хүргэх
  - Шүүмжлэлтэй сэтгэх чадвар
  - Бүтээлч сэтгэх чадвар
  - Харилцааны чадвар
  - Хамтран ажиллах чадвар
  - Иргэншлийн чадвар

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ**

Дараах удирдамж сурагч даалгавар(ууд)ыг хийж гүйцэтгэхэд зарцуулах хамгийн их хугацааг харуулна. Урьдчилан мэдэгдсэнээр багш гүйцэтгэхэд нэмэлт хугацаа шаардагдах урт хугацааны даалгавар өгч болно. Дурын нэг шөнө багш нар аливаа агуулгын чиглэлд гэрийн даалгавар өгч болохгүй.

Анги	Удирдамж
<b>БА</b>	бичиг үсэг ба/эсвэл тоонд дээд тал нь 30 минут (бие даан унших эсвэл хүнээр уншуулах зэрэг)
<b>1</b>	бичиг үсэг ба/эсвэл тоонд дээд тал нь 30 минут (бие даан унших эсвэл хүнээр уншуулах зэрэг)
<b>2</b>	бичиг үсэг ба/эсвэл тоонд дээд тал нь 30 минут (бие даан унших эсвэл хүнээр уншуулах зэрэг)
<b>3</b>	дээд тал нь 45 минут (бие даан уншихыг оруулж)
<b>4</b>	дээд тал нь 60 минут (бие даан уншихыг оруулаад); шаардлагатай бол хөгжмийн зэмсгийн дадлага хийхэд нэмэлт 15 минут
<b>5</b>	дээд тал нь 60 минут (бие даан уншихыг оруулаад); шаардлагатай бол хөгжмийн зэмсгийн дадлага хийхэд нэмэлт 15 минут

### **Багшид өгөх гэрийн даалгаврын удирдамж**

Багш нар сурагчдад дадлага хийх, бэлтгэх, судлах, гүнзгийрүүлж суралцах боломжийг олгох гэрийн даалгавар өгөх хэрэгтэй. Багш нар зан авирын үр дагавар болгож гэрийн даалгавар өгөх ёсгүй.

Ачааллыг салбарт хуваарилах, даалгаврыг нэгтгэх, тухайн шөнө хэт их ачаалал өгөхөөс зайлсхийхийн тулд гэрийн даалгаврыг аль болох хичээлүүд, баг, багш ба/эсвэл ангийн хооронд зохицуулж өгөх хэрэгтэй.

Англи хэл суралцагч, хөгжлийн бэрхшээлтэй сурагч, гоц авьяастны үйлчилгээний агуулгын чиглэлд зохистой бөгөөд шаардлагатай гэж тодорхойлсон сурагч зэрэг бүх суралцагчдын төрөл бүрийн хэрэгцээг хангахад гэрийн даалгавар чиглэх ёстой. Сурагч тусгай боловсролын төлөвлөгөө (ТБТ) эсвэл 504 төлөвлөгөөтэй бол шаардлагатай өөрчлөлт, дэмжлэгийг тусгах ёстой.

Багш санал дүгнэлт өгөхдөө тухайн агуулгын хүрээнд сурагч мэдлэг, чадвараа харуулсан эсэхэд анхаарч, сурагч, эцэг эхчүүдэд цаг тухайд нь, тууштай, ойлгомжтой, тогтмол мэдээлэх хэрэгтэй. Гэрийн ' даалгаварт сурагчийн өгсөн хариуг багш нар хянаж, ирээдүйд заах аргын шийдвэр гаргахдаа туслах зорилгоор ашиглаж болно. Ерөнхийдөө гэрийн даалгаврын талаарх ойлголтыг үнэлэхэд зөвхөн хичээлийн бага хугацааг ашиглах хэрэгтэй. Гэрийн даалгаврын үнэлгээнд сурагчийн зан байдлын үнэлгээг тусгах ёсгүй.

### **Эцэг эхэд өгөх гэрийн даалгаврын удирдамж**

Эцэг эх/асран хамгаалагч Арлингтоны улсын сургуулиудын журам I-11.2 Гэрийн даалгавар, Журмын хэрэгжилтийн дүрэм I-11.2 PIP-1 Гэрийн даалгавар, сурагчдынхаа сургууль, багш нарт тавих шаардлагыг мэдвэл.' зохино. Эцэг эх/асран хамгаалагч сурагчаасаа гэрийн даалгавраа хийсэн эсэхийг аль болох шалгах хэрэгтэй. Хэрэв сурагч гэрийн даалгаварт хэт их цаг зарцуулдаг бол (1-р хуудсанд дурдсанчлан) багш нь зохих дэмжлэгийг тодорхойлоход сурагч, эцэг эх/асран хамгаалагчид туслахын тулд эцэг эх/асран хамгаалагч багшид мэдэгдэх хэрэгтэй.

## Зуны даалгавар

Зуны даалгаврыг дадлага хийх, бэлтгэх, судлах болон/эсвэл гүнзгийрүүлж суралцахад ашиглана. Бага сургуулийн түвшинд зуны даалгаврыг зөвхөн системийн даалгавар, бичиг үсэг, тоо бодох чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн хэмжээний хөтөлбөрөөр хязгаарладаг. Системийн хэмжээний даалгаврыг Арлингтоны Улсын Сургуулийн агуулгын алба боловсруулж, ангийн түвшнээр бүх сурагчид түгээдэг (жишээ нь зуны математикийн тойм) Агуулгын чиглэлээр системийн хэмжээний нэмэлт даалгаврыг төв оффисын ажилтнууд боловсруулна. Ийм даалгаврыг сургуулийн ажилтнууд тараах бөгөөд сурагчдад өмнөх хичээлийн жилд сурсан ойлголт, чадвараа бататгах, ирэх хичээлийн жилд үзэх ухагдахуун, чадварт бэлтгэх боломжийг олгох зорилготой юм. Зуны даалгаврын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг [Журмын хэрэгжилтийн дүрэм I-11.2 PIP-2 Зуны даалгавар](#) хэсэгт оруулав.

Хэрэв багш нар тусгай хэрэгсэл (компьютер, программ хангамж, тусгай ном, хөрөнгө зарцуулах) шаарддаг зуны даалгавар өгвөл сургууль гэр бүлийн нөхцөл байдал эсвэл зуны төлөвлөгөөнөөс үл хамааран бүх сурагчид тэгш боломжоор хангах байдлаар эдгээр зүйлээр хангаж эсвэл хангах нөхцөл бүрдүүлэх үүрэгтэй. Эдгээр даалгавар сурагчдад өмнөх хичээлийн жилд сурсан ойлголт, чадвараа бататгах, ирэх хичээлийн жилд үзэх ухагдахуун, чадварт бэлтгэх боломжийг олгох зорилготой юм. Эдгээр даалгаврыг сургуулийн эхний долоо хоногт хүлээн авч, хичээлийн эхний долоо хоногт багш, сурагчид зохих ангид хянаж, үнэлнэ. Бага сургуульд сурагчдыг магтан урамшуулж, даалгавар өгч, эсвэл эдгээр зүйл байхгүй байх нь сурагчийн үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ**

### Залруулах

Ямар нэг шалтгаанаар сургуульдаа зохих түвшинд ахиц дэвшил гарахгүй байгаа сурагч сэргийлэх, дэмжих эсвэл залруулах олон төрлийн сургуулийн болон системийн хэмжээний хөтөлбөрт оролцох боломжтой. Сурагчийн ахиц дэвшлийг стандартчилсан сорилыг гүйцэтгэсэн байдал, стандартчилсан сорилтой холбоотой урьдчилсан сорил, ангийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, эцэг эх/асран хамгаалагчийн ажиглалт, багшийн ажиглалт зэрэг өргөн хүрээний шалгуураар үнэлдэг. Эцэг эх хичээлийн жилийн туршид сурагчдын ахиц дэвшлийн үнэлгээний талаарх мэдээллийг олон хэлбэрээр (уулзалт, тайлангийн хуудас, долоо хоног тутмын үүргэвчний захидал) авна. 3,4, 5-р ангид СС шалгалтад тэнцээгүй сурагчдаас сунгасан хичээлийн өдөр эсвэл заавал хамрагдах зуны сургууль гэх мэт тусгай хөтөлбөрт хамрагдахыг шаардаж болно. 3,4-р ангийн унших болон/эсвэл математикийн СС шалгалтад тэнцээгүй сурагчид 4 эсвэл 5-р ангид давтан шалгалтад оролцож болно.

### Бага сургуулийн стандартчилсан шалгалт

Виржиниа мужийн Боловсролын газар бага ангийн сурагчдыг Сургалтын Стандарт (СС) үнэлгээнд оролцохыг шаарддаг. СС үнэлгээ Виржиниа мужийн СС-тай тохирсон шалгуур үзүүлэлтэд тулгуурласан сорил юм. СС үнэлгээг хавар Виржиниа мужийн бүх улсын сургуульд явуулдаг. 3, 4, 5-р ангийн сурагчид СС шалгалт өгнө. Журмын нэмэлт мэдээллийг:

[https://go.boarddocs.com/vsba/arlington/Board.nsf/files/CCYR7U6C4199/\\$file/I-1.32%20PIP-1%20Standards%20of%20Learning%20Assessments.pdf](https://go.boarddocs.com/vsba/arlington/Board.nsf/files/CCYR7U6C4199/$file/I-1.32%20PIP-1%20Standards%20of%20Learning%20Assessments.pdf) -с авах боломжтой

### **Намар, хагас жилийн бага сургуулийн өсөлтийн үнэлгээ**

	Унших	Математик
Ангийн түвшин	3,4,5	3,4,5

## 5,6-р сарын бага ангийн СС шалгалт

	Унших	Түүх	Математик	Шинжлэх ухаан
Ангийн түвшин	3,4,5	4	3,4,5	5

Сурагч бүрийн тайланг эцэг эхчүүд ParentVue - с авах боломжтой. Арлингтоны улсын сургуулиуд, тухайн сургуулийн хураангуй үр дүнг жил бүр нийтэлдэг бөгөөд Арлингтон улсын сургуулиудын вэбсайтаас авч болно. Виржиниа мужийн Боловсролын газар жил бүр Сургуулийн гүйцэтгэлийн мэдээг нийтэлдэг бөгөөд энэ нь сургууль бүрийн сургалтын стандарт шалгалтыг хэр сайн өгсөн талаарх мэдээллийг өгдөг. Эдгээр мэдээг мужийн вэбсайт <http://www.schoolquality.virginia.gov> дээр байрлуулсан.

Арлингтон улсын сургуулиуд мөн жилийн туршид тогтмол давтамжтайгаар цэцэрлэгээс 5-р анги хүртэлх түвшинд бичиг үсэг, математикийн үнэлгээг явуулдаг. Эдгээр үнэлгээ заах үйл ажиллагааг төлөвлөх, давтлага болон/эсвэл дэмжлэг ямар сурагчдад ашиг тустай болохыг тодорхойлохын тулд сурагчдын математик, бичиг үсгийн чадварыг үнэлэх зорилготой юм.

## ЖУРМЫН МЭДЭГДЭЛ

### Сургалтын материал

Арлингтон улсын сургуулиуд бүх ангийн сурагчдад үндсэн болон тодорхой нэмэлт материалыг үнэ төлбөргүй олгодог. Сургуулийн Удирдах зөвлөл ажилтан, иргэдээс бүрдсэн батлах комиссын зөвлөмжийн дагуу улсын удирдамжийн дагуу сурах бичиг зэрэг үндсэн материалыг цаг тухайд нь баталдаг. Зөвлөл зөвлөмжийг дараахад үндэслэн үнэлдэг:

- Тэтгэлэг, сургалтын арга, техник;
- БА-12-р ангийн сургалтын хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ, дараалалд нийцэх;
- Холбогдох хичээл эсвэл ангийн түвшний зорилго, зорилтуудтай уялдаа холбоотой байх;
- Нийгмийн асуудал, соёл, угсаатны болон хэл шинжлэлийн олон янз байдлыг шийдвэрлэх; ба
- Материалыг үр дүнтэй ашиглах.

Сурах бичиг зэрэг үндсэн материал нь Мужийн Боловсролын газар ба/эсвэл Сургуулийн удирдах зөвлөлөөс тогтоосон бөгөөд ихэнх сурагч суралцахдаа ашиглах ёстой зүйл юм.

Нэмэлт материал бол үндсэн материалаас гадна ангид богино хугацаанд ашигладаг эсвэл тусгайлан заахад ашигладаг материал юм. Нэмэлт материал системийн хэмжээнд эсвэл сургуульд суурилсан байж болно. Аль ч тохиолдолд сургуулиудад хэрэглэх эдгээр бүх материалыг Журмын хэрэгжилтийн дүрэмд заасан үйл явцын дагуу батлах ёстой.

# ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ

## ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАГА СУРГУУЛИЙН ӨДӨРЛӨГ

Хичээлийн жил эхлэх өдөрлөгийг хичээлийн жилийн эхэнд намрын эцэг эхийн уулын өмнө зохион байгуулдаг. Системийн хэмжээнд хэрэглэх хөтөлбөрийн тойм, хичээлийн хэрэгслийн жагсаалт, жишиг шалгалтын хуваарь зэргийг багтаасан бичгээр үйлдсэн хуудсыг багш бэлтгэж, хичээл орсны эхний сард мэдэгддэг намрын өдөрлөгийн үеэр тарааж эсвэл өмнө гэрт нь илгээнэ. Бага ангийн сурагчдын хүрвэл зохих ангийн түвшний тодорхой зорилтуудыг сургууль тус бүрээс авах боломжтой материалд дэлгэрэнгүй харуулав:

- Ү Бага сургуулийн сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, журмын гарын авлага
- Ү Сургалтын стандартыг тусгасан агуулгын чиглэл бүрийн сургалтын хөтөлбөрийн удирдамж
- Ү Сургалтын материал
- Ү Виржиниа мужийн улсын сургуулиудын сургалтын стандартууд (СС)

Эцэг эх, багш нарын арга хэмжээний зорилго гэрт илгээсэн хуудасны талаар ярилцах, тухайн жилийн өвөрмөц хөтөлбөрийн төлөвлөгөөг тайлбарлах, гэрийн даалгаврын журмыг хэлэлцэх, заах материалыг өгөхөд оршино.

## СУРАГЧДЫН ДЭВШИЛ, ДҮНГ МЭДЭЭЛЭХ

Дүүргийн тэргүүн, ажилтнууд анги тус бүрд хэрэглэх тайлангийн төлөвлөгөөг Удирдах зөвлөлөөр батлуулахаар бэлтгэнэ. Тайлангийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг сургуулийн захирлаар дамжуулан Сургалтын ахлагч, Сургуулийн дэмжлэгийн дарга хариуцаж ажиллана. Багш нар сурагч бүрийн амжилтыг дэлгэрэнгүй, системтэй бүртгэн хөтөлж, суралцаж буй ангийн тайлангийн маягтын дагуу сурагч бүрийн ахиц дэвшлийг эцэг эх/асран хамгаалагчдад үе үе мэдээлнэ. Жилийн эцсийн дүнгийн тайлангаас бусад тохиолдолд багш нар үнэлгээний хугацаа дууссанаас хойш дор хаяж хоёр бүтэн хичээлийн өдрийн дараа дүнг илгээх ёстой.

### **Эцэг эх/асран хамгаалагчдад мэдээлэл өгөх журам, заавар**

“Сургууль бүр хичээлийн жил бүрийн эхэнд сурагч, эцэг эх, асран хамгаалагч нарт дараах зүйлийг авах боломжтой эсэх, авах эх сурвалжийн талаар мэдээлэл өгнө:

- Хүүхдийнхээ ангийн түвшинд эсвэл ахлах сургуульд хүрвэл зохих, 8 VAC 20-131-70 хуулийн заалтын дагуу боловсруулсан сургалтын зорилтууд, хүүхдийн хичээл тус бүрийн сургалтын хөтөлбөрийн хуулбар, сургуулийн хэлтсийн тушаал дэвших, хадгалах, залруулах журмын хуулбар;
- Хүүхдийн анги эсвэл хичээлийн шаардлагад хамаарах сургалтын стандартууд, хүүхдийн дараагийн СС шалгалтын ойролцоо огноо, болзошгүй нөлөөлөл; ба
- 8 VAC 20-131-30 хуульд заасны дагуу стандарт болон ахисан түвшний боловсролын дипломд тавигдах бүх шаардлага, анги дэвшүүлэх, хадгалах талаар баримтлах Удирдах зөвлөлийн журмыг бүх ангийн бүх түвшний сурагчдад жил бүр мэдэгдэнэ. Хэлтсийн дарга 8VAC20-131-390 А (8 VAC 20-131-270) хуулийн шаардлагын дагуу тус Газар (Виржиниа Боловсролын газар) тайлагнана”

### **Сурагчийн амжилтыг мэдээлж, үнэлэх**

Хичээлийн жил бүр эхлэхээс өмнө багш бүр Арлингтоны улсын сургуулиудын сургалтын хөтөлбөрт заасан стандарт, зорилтуудыг нэгтгэн, сургалтын чиглэл бүр дэх системийн зааврын дагуу сурагчдын хичээлийн дүнг тодорхойлох зорилгоор анги тус бүрд хэрэглэх стандарт, шаардлагыг тогтооно. Эдгээр стандарт, шаардлагыг хичээлийн жилийн эхэнд сурагчид, эцэг эх/асран хамгаалагчдад өгнө. Сурагчийн үнэлгээ сурагчдын зан төлөвийг бус харин сурагчийн амжилтыг харуулдаг.

Дүүргийн боловсруулсан жишиг үнэлгээг сурагч хэр хийсэн болохыг эцэг эх/асран хамгаалагчид мэдээлж, сурагчдын дүнг тооцоолоход оруулахгүй.

### **Бага сургуулийн сурагчдын эцэг эх/асран хамгаалагчдад мэдээлэх**

Бүх эцэг эх/асран хамгаалагч ахиц дэвшлийн тайланг хүлээн авна. Тэргүүн бага ангийн түвшинд стандартад суурилсан болон уламжлалт гэсэн хоёр тайлангийн системийг баталсан. Систем бүрийн тайлбарыг доор өгөв. Баталсан үнэлгээний системээс



нөгөөд шилжих шийдвэрийг Тэргүүн сургуулийн ажилтан, иргэдийн санал хүсэлтийг тусган гаргаж, сургуулийн хамт олон, сурган хүмүүжүүлэх арга зүй, үнэлгээнд тулгуурлан гаргах хэрэгтэй.

## ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ

### СТАНДАРТАД СУУРИЛСАН ТАЙЛАН БА-5-р анги

Бэлтгэл ангиас 5-р анги хүртэлх сурагч англи хэл уран зохиол (унших/бичих), математик, шинжлэх ухаан, нийгэм судлал, урлаг, дуу хөгжим, биеийн тамирын хичээлийн стандартад суурилсан ахиц дэвшлийн тайланг хүлээн авна. Бэлтгэл ангийн сурагчид жилд хоёр удаа, 1-5 дугаар ангийн сурагчид улирал тутам тайлан хүлээн авдаг.

Дөрвөн бичмэл тайланг есөн долоо хоногийг хуваариар гаргана. Эцэг эх, асран хамгаалагч, багш нарын хоёр уулзалтыг намар, хаврын улиралд хийхээр төлөвлөнө. Анхны уулзалтыг хичээлийн жилийн эхэн болон анхны бичмэл тайлангийн хооронд хийнэ. Хоёр дахь уулзалтыг хоёр, гурав дахь бичмэл тайлангийн хооронд хийнэ.

Эцэг эх, асран хамгаалагч, багш нарын уулзалтыг цаг товлож хийнэ. Намрын уулзалтын өмнө системийн хэмжээний хөтөлбөрийн тойм, сургалтын материалын жагсаалт, стандартчилсан шалгалтын хуваарь зэргийг багтаасан хуудсыг эцэг эх/асран хамгаалагчдад илгээнэ. Мөн намар эцэг эх, асран хамгаалагчийн бүлгийн уулзалтыг зохион байгуулж, тус хуудсыг ярьж хэлэлцэх, тухайн жилийн хөтөлбөрийн төлөвлөгөөг тайлбарлах, сургалтын материалыг үзүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагч багш нарын ээлжит уулзалт дараах нөхцөлийг хангана:

- уулзалт хорин минут, уулзалтын хооронд арван минут;
- хичээлийн ердийн бус цагаар уулзалт хийх шаардлагатай үед уян хатан байх, нөхөн олгох цаг; ба
- нэг өдрийн турш ойролцоогоор арван хоёр уулзалт хийх хуваарь.

Уулзалт багшийн саадгүй төлөвлөх цагтай зөрчилдөхгүй; шаардлагатай бол орлох багш байлгана.

Стандартад суурилсан ахиц дэвшлийн тайлан Виржиниа мужийн сургалтын стандарт (CC), Арлингтоны улсын сургуулиудын анги тус бүрээр тогтоосон сургалтын шаардлагад үндэслэн сурагчдын сурлагын ахиц дэвшлийн талаар эцэг эх/асран хамгаалагчдад мэдээлэхэд тусалдаг. Энэ тайланд сурлагын амжилт, ахиц гаргах боломжуудыг онцолно. Стандартад суурилсан ахиц дэвшлийн тайланд уламжлалт үсгэн дүнг ашигладаггүй бөгөөд гүйцэтгэлийн түвшнийг ашиглан агуулгын талбар бүрд тодорхойлсон сургалтын гол стандартуудын ахиц дэвшлийг мэдээлдэг. Уг тайланд тогтоосон стандартын хувьд сурагчийн түвшнийг илүү бүрэн тайлбарлаж болох багшийн тайлбарыг мөн оруулна.

### Арлингтон улсын сургуулиудын стандартад суурилсан тайлан Гүйцэтгэлийн түвшин

Стандартыг хангасан	сурагч стандартыг эзэмшсэн гэдгээ байнга харуулдаг
Эзэмшихэд ойртож байна	сурагч стандартыг эзэмших шатанд байна
Эзэмшиж байна	сурагч стандартын талаарх эхний ойлголтоо дэмжлэгтэйгээр харуулдаг
Нотлох баримт хангалтгүй	Тухайн стандарт/чадварыг эзэмших сурагчийн түвшнийг тодорхойлоход багшид нотлох баримт байхгүй

### Стандартад суурилсан мэдээлэх системд тусгай сурагчдад мэдээлэх Тусгай боловсрол:

Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагч ангийн түвшинд хүрэх чадваргүй бөгөөд стандарт сургалтын хөтөлбөр, хичээл, чадварын талбарт томоохон өөрчлөлт оруулах шаардлагатай бол түүнийг тусгай боловсролын хөтөлбөрийн (ТБХ) зорилгод нийцүүлэн үнэлбэл зохино. **Өөрчлөлт** гэж ийм тохиолдолд тухайн хичээл, стандарт, шалгалтын стандарт эсвэл ангийн түвшний шаардлагыг үндсээр нь өөрчлөх эсвэл бууруулах боломж олгож, хичээл, стандарт эсвэл шалгалтын бэлтгэлд гарсан томоохон өөрчлөлтийг хэлнэ.

Өөрчлөлтийг явцын тайланд хүүрнэж тайлбарлах замаар эцэг эх/асран хамгаалагчдад мэдэгдэнэ.

**Англи хэл суралцагч:** Англи хэл суралцагчид ангийн түвшний шаталсан агуулгаар суралцах боломжтой. Явцын тайлан дахь тайлбарт англи хэл суралцагчдад хэрхэн өөрөөр зааж хандсаныг тусгах хэрэгтэй.

**Гоц авьяастай суралцагч:** Стандарт, хичээл эсвэл чадварын чиглэлээр сургалтын хөтөлбөрийн өөрчлөлттэй сурч байгааг тогтоосон суралцагчид зохих хэмнэл, ачааллын тухай улирал тутмын тайланд мэдээлнэ. Виржиниа мужийн 8VAC 20-40-40 хуульд дурдсанчлан эцэг эх/асран хамгаалагчид эдгээр өөрчлөлтөд үндэслэн сурагчдын үр дүн, ахицын талаар мэдээлсэн ялгаатай маягыг улирал бүр авдаг.

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ**

### **Стандартад суурилсан тайлангийн системийн хүчин чармайлт/Ажлын болон нийгэмших чадвар/оролцоо**

Стандартад суурилсан ахиц дэвшлийн тайланд ажил, нийгэмших чадвар эсвэл C.A.R.E.S. тухай мөн мэдээлнэ C.A.R.E.S. гэж хамтын ажиллагаа, баталгаа, хариуцлага, нинжин сэтгэл, өөрийгөө хянах гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд Хариуцлагатай анги зэрэг нотолгоонд суурилсан, шаталсан нийгэмшил/сэтгэл хөдлөлийг заах хандлагын системийг хэрэгжүүлдэг сургуулиудад ашигладаг. Ажлын болон нийгэмших чадвар эсвэл C.A.R.E.S -г мөн тодорхойлсон гүйцэтгэлийн түвшнийг ашиглан мэдээлдэг.

### **УЛАМЖЛАЛТ ТАЙЛАН БА-5-р АНГИ**

Уламжлалт тайлангийн хуудас Сурагчийн ахиц дэвшлийг дараах байдлаар илэрхийлдэг:

### **БЭЛТГЭЛ АНГИ**

#### **Тэмдэглэгээний кодын тайлбар**

Эдгээр тэмдгийг сурагчийн эзэмших хэрэгтэй ур чадвар, ойлголтод тулгуурласан ахиц дэвшлийг илэрхийлэхэд ашигладаг:

#### **X - Хангасан**

#### **Сурагч зан авир эсвэл ур чадварыг тууштай хангасан**

Сурагч зан авир эсвэл ур чадварыг тууштай хангасан

Сурагч үндсэн ойлголт, ур чадварыг ойлгосноо бие даан харуулдаг

#### **A - Ахиж буй**

#### **Сурагч зан төлөв, ур чадвараа хөгжүүлэх шатанд байна**

Сурагч үндсэн ур чадвар, стратеги эсвэл үзэл ойлголтыг дутуу харуулж эсвэл хэрэгжүүлдэг Сурагч стандартыг хэсэгчлэн хангасан. Сурагч стандартыг хэсэгчлэн хангасан

#### **Э - Эхэлж буй**

#### **Сурагч зан авир, ур чадвараа харуулж эхэлж буй**

Сурагч ойлголт, ур чадварыг ойлгож эхэлж байгаа бөгөөд эдгээр даалгаврыг гүйцэтгэхэд багшийн дэмжлэг шаардлагатай. Сурагч ойлголт, ур чадварыг ойлгож эхэлж байгаа бөгөөд эдгээр даалгаврыг гүйцэтгэхэд багшийн дэмжлэг шаардлагатай.

#### **XУ - Хараахан үгүй**

#### **Сурагч зан төлөв, ур чадвараа хараахан харуулаагүй**

#### **ҮЭ – Үзэж эхлээгүй**

#### **Ур чадварыг үзэж эхлээгүй**

Эцэг эх/асран хамгаалагчтай ил тод харилцах зорилгоор Сургуулийн өмнөх насны хүүхдийн албаны нийтэлсэн **Бэлтгэл ангийн үзүүлэлтүүдийн тайлбарыг (БАҮТ)** нийтэлж, хоёр жил тутмын ахиц дэвшлийн тайланд хавсаргана. Явцын тайлангийн үзүүлэлт эсвэл тайлбарт бэлтгэл ангид эзэмших хэрэгтэй олон ур чадвар, ойлголтуудыг тусгадаг. Бэлтгэл ангид хамаарах Виржиниа мужийн сургалтын стандарт (CC), сурах дадал зуршил, нийгэмшлийн хөгжлийг мөн тусгасан.

Хүүхэд бүр өөрийн хурдаар хөгжиж, төлөвшдөг хувь хүн юм. Нэг ангийн хүүхдүүд бүлгийнхээ бусдаас эрс ялгаатай байж болно. **Бэлтгэл ангийн явцын тайлан, бэлтгэл ангийн үзүүлэлтүүдийн тайлбар (БАҮТ)** хоёулаа сургууль, гэрийн хооронд ил тод харилцаа холбоо тогтоох зорилготой юм. Сургууль, эцэг эх хамтран ажилласнаар хүүхдүүд маань боловсрох, амжилттай суралцах хамгийн сайн боломжтой болно.

## ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ

### УЛАМЖЛАЛТ ТАЙЛАН БА-1-5-р АНГИ

#### 1-5 хүртэлх анги

Дөрвөн бичмэл тайланг есөн долоо хоногийг хуваариар гаргана. Бичмэл тайлан бүр сурагчийн хувийн болон сурлагын өсөлтийг үнэлж, багшид тайлбар бичих зай гаргана.

Эцэг эх, асран хамгаалагч, багш нарын хоёр уулзалтыг намар, хаврын улиралд хийхээр төлөвлөнө. Анхны уулзалтыг хичээлийн жилийн эхэн болон анхны бичмэл тайлангийн хооронд хийнэ. Хоёр дахь уулзалтыг хоёр, гурав дахь бичмэл тайлангийн хооронд хийнэ.

Эцэг эх, асран хамгаалагч, багш нарын уулзалтыг цаг товлож хийнэ. Намрын уулзалтын өмнө системийн хэмжээний хөтөлбөрийн тойм, сургалтын материалын жагсаалт, стандартчилсан шалгалтын хуваарь зэргийг багтаасан хуудсыг эцэг эх/асран хамгаалагчдад илгээнэ. Мөн намар эцэг эх, асран хамгаалагчийн бүлгийн уулзалтыг зохион байгуулж, тус хуудсыг ярьж хэлэлцэх, тухайн жилийн хөтөлбөрийн төлөвлөгөөг тайлбарлах, сургалтын материалыг үзүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагч багш нарын ээлжит уулзалт дараах нөхцөлийг хангана:

- уулзалт хорин минут, уулзалтын хооронд арван минут;
- хичээлийн ердийн бус цагаар уулзалт хийх шаардлагатай үед уян хатан байх, нөхөн олгох цаг; ба
- нэг өдрийн турш ойролцоогоор арван хоёр уулзалт хийх хуваарь.

Уулзалт багшийн саадгүй төлөвлөх цагтай зөрчилдөхгүй; шаардлагатай бол орлох багш байлгана.

### Бүх агуулгын чиглэлийн уламжлалт тайлан 1-2-р анги

#### 1-2-р анги

“А” - Ахиц гаргаж буй гэж сурагч анги бүрд хичээл бүрд дүүргээс тогтоосон зорилтыг амжилттай ойлгож, хэрэглэдэг болохоо харуулсныг илэрхийлнэ.

“Г” Ахиц гараагүй гэж сурагч анги бүрд хичээл бүрд дүүргээс тогтоосон дүүргээс тогтоосон ангийн зохих зорилтуудыг ойлгож, хэрэгжүүлэхгүй байгааг илэрхийлнэ.

Хичээл бүрийн доор жагсаасан дэд ангилал тус бүрд сул тал (#), давуу тал (+), хангалттай ахиц дэвшил (тэмдэг байхгүй) хэсгийг заана.

### Уран зохиол (бичих, унших), математик, шинжлэх ухаан, нийгэм судлалын уламжлалт тайлан 3-5-р анги

#### 3-5-р анги

А – Ангийн түвшний шаардлагаас давсан

“А” гэж тухайн сурагч ангийн түвшний шаардлагыг тогтмол давуулан биелүүлж байгааг хэлнэ хүлээлт. Даалгавруудыг зөв, бүрэн гүйцэд, цаг тухайд нь хийдэг. Ерөнхий гүйцэтгэл, сурагчийн хийсэн ажил илүү сайн бөгөөд хувь хүний сэтгэлгээний өндөр түвшнийг илэрхийлдэг.

- В – Ангийн түвшний шаардлагаас ихэвчлэн давсан** “В” гэж тухайн сурагч ангийн түвшний шаардлагыг ихэвчлэн давуулан биелүүлж байгааг хэлнэ. Даалгавруудыг зөв, бүрэн гүйцэд, цаг тухайд нь хийдэг.
- С – Ангийн түвшний шаардлагыг хангана** “С” гэж тухайн сурагч ангийн түвшний шаардлагыг хангаж байгааг хэлнэ. Даалгаврыг цаг тухайд нь хийдэг бөгөөд ерөнхийдөө бүрэн, зөв байдаг. Тухайн ангийн зорилгод хүрсэн.
- Д – Ангийн түвшний шаардлагыг хангаагүй Тэнцэнэ** “Д” гэж тухайн сурагч ангийн түвшний шаардлагыг хангахгүй байгааг хэлнэ. Даалгаврыг ихэвчлэн хугацаандаа хийгээгүй, дутуу эсвэл буруу байж болно. Хамгийн бага зорилгод хүрсэн. Энэ түвшин бол анги дэвшихэд хүлээн зөвшөөрсөн доод хэмжээ юм.
- Е – Ангийн түвшний шаардлагыг хангаагүй - Тэнцээгүй** “Е” гэж тухайн сурагч ангийн түвшний шаардлагыг хангахгүй байгааг хэлнэ. түвшин хангалтгүй. “Е түвшинд анги дэвшихийг зөвшөөрөхгүй.

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ**

### **3-5-р ангийн дуу хөгжим, биеийн тамир, урлагийн амжилт**

Дуу хөгжим, биеийн тамир, урлагийн агуулгын чиглэлээр гаргасан амжилтыг дараах тэмдэглэгээг ашиглан мэдээнэ:

- Э – Эхэлж буй:** Сурагч агуулгын материалтай танилцсан.
- А – Ахиж байна:** Сурагч одоогоор ур чадвар, агуулгын материалын талаар ойлголттой болж байна.
- Ч – Чадвартай:** Сурагч бодитой хэрэглэх ур чадвараа харуулсан бөгөөд агуулгын материалыг хэзээ, хэрхэн гүйцэтгэх талаар ойлголттой болсон.
- О – Онц:** Сурагч гайхалтай ур чадвар, ойлголтоо харуулж, сурсан стандартыг эзэмшиж, тэдгээрээс давж гарсан.

### **Уламжлалт тайлангийн системийн хичээл зүтгэл/Сурах болон нийгэмших чадвар/оролцоо 1-5-р анги**

Амжилтаас гадна сурагчийн хичээлийн чиглэл тус бүр дэх хичээл зүтгэл, зарим тусгай хичээлийн амжилт, сурах дадал зуршил, нийгэмших ур чадварыг дараах тэмдгээр үнэлж, тэмдэглэнэ:

- О – Онц**
- Х - Хангалттай**
- С - Сайжирч байна**
- СШ- Сайжруулах шаардлагатай**

**Тусгай боловсрол:** Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагч ангийн түвшинд хүрэх чадваргүй бөгөөд стандарт сургалтын хөтөлбөр, хичээл, чадварын талбарт томоохон өөрчлөлт оруулах шаардлагатай бол түүнийг ТБХ-ийн зорилгод нийцүүлэн үнэлбэл зохино.

Өөрчлөлт гэж ийм тохиолдолд тухайн хичээл, стандарт, шалгалтын стандарт эсвэл ангийн түвшний шаардлагыг үндсээр нь өөрчлөх эсвэл бууруулах боломж олгож, хичээл, стандарт эсвэл шалгалтын бэлтгэлд гарсан томоохон өөрчлөлтийг хэлнэ. Өгсөн дүнгийн хажууд буй од (\*) өөрчлөлт ашигласныг илэрхийлж байгаа бөгөөд эцэг эх/асран хамгаалагчдад тайлбар өгөх хэрэгтэй хэсэг байгааг харуулна. Хэрэв сурагч сургалтын хөтөлбөрт хамрагдахын тулд тусгай дэмжлэг авч байгаа бол (\*) тэмдгийг ашиглах ёсгүй. Стандарт сургалтын хөтөлбөр, хичээл эсвэл ур чадварын талбарт томоохон өөрчлөлт оруулсан тохиолдолд л од тэмдгийг ашиглах хэрэгтэй.

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ**

**Англи хэл суралцагч:** Англи хэл суралцагчид ангийн түвшний шаталсан агуулгаар суралцах боломжтой. Тавьсан дүнгийн хажууд буй луувангийн тэмдэг (^) англи хэл суралцагчийн ялгааг тайлбарлах шаардлагатай нэмэлт (өөрөөр хэлбэл сурлагын хуудас дээрх нэмэлт тайлбар) байгааг харуулна.

**Гоц авьяастай суралцагч:** Стандарт, хичээл эсвэл чадварын чиглэлээр сургалтын хөтөлбөрийн өөрчлөлттэй сурч байгааг тогтоосон суралцагчид мөн улирал бүр ялгааны тайланг хүлээн авна. Виржиниа мужийн 8VAC 20-40-40 хуульд дурдсанчлан эцэг эх/асран хамгаалагчид эдгээр өөрчлөлтөд үндэслэн сурагчдын үр дүн, ахицын талаар мэдээлсэн ялгаатай маягыг улирал бүр авдаг.

## **АХИЦЫН БУСАД ТАЙЛАН**

### **Өөрчилсөн явцын тайлан**

Зарим сурагч тусгай хөтөлбөрт хамрагддаг бөгөөд стандарт ахиц дэвшлийн тайланг ашиглахад тохиромжгүй байдаг. Эдгээр сурагчдын ихэнхийг хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон бөгөөд тусгай боловсрол болон/эсвэл холбогдох үйлчилгээ хүлээн авдаг. Хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон сурагч бүр сургуулийн ажилтан, эцэг эх, зохистой бол сурагчийн боловсруулсан Тусгай боловсролын хөтөлбөртэй (ТБХ) байдаг. ТБХ-г хэрэгцээтэй холбоо хамааралтай тодорхой зорилго, зорилтуудыг тусгана.

Тусгай боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй сурагчид сурлагын явцын тайланг ердийн боловсролын бичгээр өгдөгтэй ижил давтамжаар тусгай боловсролын багшаас авах ёстой. Эдгээр тайлан ердийн боловсролын ахиц дэвшлийн тайлангаас гадна байх бөгөөд ТБХ-ийн зорилтуудын ахиц дэвшлийг тусгаж боловсруулах хэрэгтэй.

Тусгай боловсролын багш нар тогтмол товлодог мөн эцэг эхийн уулзалтад мөн оролцдог. Бусад тайлагнах журам стандарт бус тайлан болох ба энэ гарын авлагад заасан журмын дагуу боловсруулах ёстой.

Тусгай нөхцөл байдлын улмаас жилийн турш амжилтгүй дүн авч болох ердийн хөтөлбөрийн сурагчдад зориулж тайлбарласан тайланг ашиглаж болно. Стандарт ахиц дэвшлийн тайлангийн оронд тайлбарлаж бичсэн тайланг оруулах шийдвэрийг гаргахад багш, эцэг эх, захирал оролцдог. Тайлбарлах тайланд сурагчийн унших, математик, зөв бичгийн дүрмийн мэдлэгийн түвшнийг тусгахаас гадна анги дэвших эсвэл үлдэхтэй холбоотой сурагчийн статусыг заана.

### **Стандарт бус тайлан**

Тухайн сургуулийн зохих шалтгааны улмаас батлагдсан журмын дагуу стандартчилсан тайлагналын системээс ялгаатай тайлангийн системийг боловсруулж, ашиглаж болно. Стандарт бус тайланг батлах зохих шалтгаанд шинэлэг хөтөлбөрүүд, хүн ам зүйн ер бусын хүчин зүйл эсвэл харилцааны тусгай хэрэгцээ зэрэг хүчин зүйлс багтаж болно. Стандарт бус тайлан анги дэвших, үлдэх журамтай нийцэх ёстой.

Зөвхөн стандарт тайлангийн маягыг нөхсөн тайлангийн мэдээллийг тухайн сургуулийн үзэмжээр нэмж оруулж болох бөгөөд стандарт бус тайланг ашиглах журам үйлчлэхгүй.

Тодорхой бага сургуультай холбоотой мэргэжлийн ажилтнууд эсвэл иргэд тайлангийн тогтолцоог өөрчлөхийг дараах байдлаар санал болгож болно.

1. Стандарт бус тайлагнах тогтолцооны саналыг сургуулийн ажилтнууд, өөрчлөлтийг санаачилсан сургуулийн хамт олны төлөөлөл судлах хэрэгтэй. Саналыг төв оффис руу шилжүүлэхээс өмнө Эцэг эх/Багшийн холбоонд илгээж батлуулах ёстой.

2. Саналыг Сургалтын ерөнхий захиралд бичгээр гаргаж, Тэргүүний зөвлөмжийг хүснэ.

### **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- ЭЦЭГ ЭХЭД МЭДЭЭЛЭХ**

3. Эцсийн зөвлөмжийг Тэргүүн Сургуулийн удирдах зөвлөлд оруулж батлуулна. Стандарт бус явцын тайлангийн саналыг жил бүр ирүүлэх ёстой.

## **ЖУРМЫН МЭДЭГДЭЛ- АНГИ ДЭВШИХ, ҮЛДЭЭХ**

### **Анги дэвших**

Анги дэвших эсэх нь бага сургуулийн ангийн түвшин тус бүрд тавьсан зорилтуудтай холбоотой чадвар, мэдлэг, сурах дадлыг эзэмшихэд хувь хүний гаргасан ахиц дэвшилд суурилдаг.

Бага сургуульд анги дэвшихэд дээр дурдсан журамд заасан ерөнхий хэв маягийг дагаж мөрддөг. Ихэвчлэн БА-5-р ангид анги хэвийн дэвшсэний дараа бага сургуулиас дунд анги руу дэвшдэг. Гэсэн хэдий ч тухайн сурагчийн нөхцөл байдал энэ дүрмээс хазайхыг шаардаж болно; бага сургуульд хурдасгаж эсвэл удааширч анги дэвшдэг.

Аль ч тохиолдолд хүүхдийн эцэг эх хурдасгах эсвэл ангид үлдэхэд хүргэх төлөвлөлтөд оролцдог. Анги тус бүрийн түвшинд тогтоосон зорилтуудтай холбоотой ангид сурах байдал, багшийн дүгнэлт, амжилтын сорил, шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон хэмжилт зэрэг сурагчийн амжилтыг илэрхийлэх хүчин зүйлсийг харгалзана.

### **Үлдээх**

Боловсролын ахиц нь дараагийн ангид дэвшин орох үндэслэлгүй тохиолдолд сурагчийг ангид үлдээдэг. Үлдээх эсэхийг анги тус бүрийн түвшинд тогтоосон зорилтуудтай холбоотой сурлагад үндэслэж суурилдаг.

### **Үлдээх шийдвэр**

Сургуулийн ажилтнууд Сурагчийн урт хугацааны амжилтад тус дөхөм болох тохиолдолд Сурагчийг үлдээхийг зөвлөдөг. Харгалзах хүчин зүйл:

- Ү унших, бичих, математикийн үндсэн чадварыг ангидаа харуулах, сурлагын хуудасны дүн, амжилтын сорил, шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон хэмжилт.
- Ү анги тус бүрийн түвшинд тогтоосон зорилтуудтай холбоотой сурагчийн амжилтын тухай багшийн санал бодол.
- Ү сурагчийг ангид үлдээх, үндсэн ур чадварын чиглэлээр залруулах, англи хэлний мэдлэгтэй холбоотой өмнөх түүх.

### **Эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх**

Үлдээх эсэх асуудлыг авч үзэхэд сурагчийн эцэг эх хаврын эцэг эхийн уулзалтаас хэтрэхгүй эрт төлөвлөлтөд оролцдог. Хичээлийн жил эхэлсний дараа шилжиж ирсэн сурагчдыг өөрөөр авч үзэж болно. Үлдээх нь зүйтэй гэж үзвэл эцэг эхтэй зөвлөлдөж, яагаад үлдээх болсон шалтгааныг ярьж хэлэлцэнэ. Хуваарилах тухай эцсийн үүргийг захирал хүлээнэ.

## ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ

Арлингтон улсын сургуулиуд 26 бага сургуульд төрөл бүрийн хөтөлбөр, үйлчилгээг санал болгодог. Арлингтоны бүх бага сургуулийг Виржиниа мужийн боловсролын зөвлөл, Коллеж, сургуулиудын өмнөд холбооноос магадлан итгэмжилсэн. Виржиниа муж дахь сургуулиудын магадлан итгэмжлэлийн стандартууд чанартай боловсролын үндэс суурийг тавих зорилготой. Эдгээр стандарт бүх сурагчийн хэрэгцээ, сонирхол, хүсэл эрмэлзэлд нийцсэн боловсролын хөтөлбөрүүдийг санал болгохын тулд үргэлжлүүлэн хүчин чармайлт гаргахад нь сургуулиудад туслах заавар, чиглэл өгдөг.

Дараах хэсэгт та бага сургууль бүрийн жагсаалт, улс даяар хэрэгждэг болон тухайн бага сургуульд байдаг хөтөлбөр, үйлчилгээний тайлбарыг авна. Харьяа болон дүүргийн хэмжээний сургуулийн сонголтуудын талаарх мэдээллийг Бага сургууль: <http://apsva.us/publications/>. Эцэг эхчүүдэд зориулсан бүртгэлийн гарын авлагаас авна уу. Нэмэлт мэдээллийг Арлингтон улсын сургуулиудын вэбсайтаас авах боломжтой.

### **Abingdon бага сургууль**

David Horak, Захирал  
Anne Oliveira болон Michele Micael, Орлогч Захирал  
3035 S. Abingdon Street, 22206  
703-228-6650  
<https://abingdon.apsva.us>

### **Arlington Science Focus сургууль**

Mary Begley, Захирал  
Barbara Jones, Орлогч Захирал  
1501 N. Lincoln Street, 22201  
703- 228-7670  
<https://asfs.apsva.us>

### **Arlington Traditional сургууль**

Sam Podbelski, Захирал  
Inga Schoenbrun, Орлогч Захирал  
1030 N. McKinley Road, 22205  
703- 228-6290  
<https://ats.apsva.us>

### **Ashlawn бага сургууль**

Frances Lee, Захирал  
Meghan Neary, Орлогч Захирал  
5950 North 8<sup>th</sup> Road, 22205  
703- 228- 6650  
<https://ashlawn.apsva.us>

### **Barcroft бага сургууль**

Judy Apostolico-Buck, Захирал  
Gabriela Rivas, Орлогч Захирал  
625 Wakefield Street, 22204  
703- 228-5838  
<https://barcroft.apsva.us>

### **Barrett бага сургууль**

Catherine Han, Захирал  
Amin Littman, Орлогч Захирал  
4401 North Henderson Road, 22203  
703- 228-6288  
<https://barrett.apsva.us>

### **Campbell бага сургууль**

Maureen Nesselrode, Захирал  
Karen Anselmo, Орлогч Захирал  
737 S. Carlin Springs Road, 22204  
703- 228- 6770  
<https://campbell.apsva.us>

### **Cardinal бага сургууль**

Colin Brown, Захирал  
Gina Miller, Орлогч Захирал  
1644 N. McKinley Road, 22205  
703- 228-5280  
<https://cardinal.apsva.us>

### **Carlin Springs бага сургууль**

Д-р. Melaney Maskin, Захирал  
Marcelo Flores, Орлогч Захирал  
5995 South 5<sup>th</sup> Road, 22204  
703- 228-6645  
<https://carlinsprings.apsva.us>

### **Claremont бага сургууль**

Jessica Panfil, Захирал  
Erin Wales-Smith, Орлогч Захирал  
4700 S. Chesterfield Road, 22206  
703- 228-2685  
<https://claremont.apsva.us>



**Discovery бага сургууль**

Erin Russo, Захирал  
Д-р. Judith Seeber, Орлогч Захирал  
5241 N. 36<sup>th</sup> Street, 22207  
703- 228-2685  
<https://discovery.apsva.us>

**Fleet бага сургууль**

Jennifer Gildea, Захирал  
Rebecca Ward, Орлогч Захирал  
115 South Old Glebe Road, 22204  
703- 228-5820  
<https://fleet.apsva.us>

**Hoffman-Boston бага сургууль**

Heidi Smith, Захирал  
Suzanne Paul, Орлогч Захирал  
1415 S. Queen Street, 22204  
703- 228-5845  
<https://hoffmanboston.apsva.us>

**Jamestown бага сургууль**

Michelle McCarthy, Захирал  
Dr. Monica Roaché, Орлогч Захирал  
3700 N. Delaware Street, 22207  
703- 228-5275  
<https://jamestown.apsva.us>

**Long Branch бага сургууль**

Jessica DaSilva, Захирал  
Carolyn Jackson, Орлогч Захирал  
33 N. Fillmore Street, 22201  
703- 228-4220  
<https://longbranch.apsva.us>

**Nottingham бага сургууль**

Д-р Eileen Gardner, Захирал  
Д-р Megan Lynch, Орлогч Захирал  
5900 Little Falls Road, 22207  
703- 228-5290  
<https://nottingham.apsva.us>

**Randolph бага сургууль**

Carlos Ramirez, Захирал  
Jennifer Denino, Орлогч Захирал  
1306 S. Quincy Street, 22204  
703- 228-5830  
<https://randolph.apsva.us>

**Tuckahoe бага сургууль**

Dustin Barnes, Захирал  
Michele Maurer, Орлогч Захирал  
6550 N. 26<sup>th</sup> Street, 22213  
703- 228-5288  
<https://tuckahoe.apsva.us>

**Drew бага сургууль**

Tracy Gaither, Захирал  
James Welch, Орлогч Захирал  
3500 S. 24<sup>th</sup> Street, 22206  
703- 228-5825  
<https://drew.apsva.us>

**Glebe бага сургууль**

Jaime Lee Borg, Захирал  
Ingrid Clark-Marshall, Орлогч Захирал  
1770 N. Glebe Road, 22207  
703- 228-6280  
<https://glebe.apsva.us>

**Innovation бага сургууль**

Claire Peters, Захирал  
Kathryn White, Орлогч Захирал  
2300 Key Blvd, 22201  
703- 228-2700  
<https://innovation.apsva.us>

**Key сургууль - Escuela Key**

Marleny Perdomo, Захирал  
Erika Sanchez, Орлогч Захирал  
855 North Edison Street, 22205  
703- 228-8495  
<https://key.apsva.us>

**Арлингтоны Монтессори Улсын Сургууль**

Catarina Genove, Захирал  
Yolanda Nashid, Орлогч Захирал  
701 S. Highland Street, 22204  
703- 228-8871  
<https://montessori.apsva.us>

**Oakridge бага сургууль**

Д-р Lynn Wright, Захирал  
Laurel Cerrud, Орлогч Захирал  
1414 S. 24<sup>th</sup> Street, 22202  
703- 228-5840  
<https://oakridge.apsva.us>

**Taylor бага сургууль**

Katie Madigan, Захирал  
Caitlin Sherman, Орлогч Захирал  
2600 N. Stuart Street, 22207  
703- 228-6275  
